



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 749

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн худалдан авах ажиллагааны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн нийт 11,521,473.31 (арван нэгэн сая таван зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун далан гурван төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 7,349,161.92 (долоон сая гурван зуун дөчин есөн мянга нэг зуун жаран нэгэн төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал М.Адилсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003085

31-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн
749 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АНАГААХ ШИНЖЛЭХ УХААНЫ
ИХ СУРГУУЛИЙН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он/үнэлгээ хийсэн	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөг)	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг
1	Компьютер dell optiplex 7070 /SE2417HGX	3/16/2023	5	972,106.67	4,860,533.35	3,238,004.46	1,622,528.89
2	Компьютер dell optiplex 3070 /SE2219HX m	3/16/2023	9	676,463.33	6,088,169.97	3,792,951.91	2,295,218.06
3	Принтер HP Laserjet MFP 137	3/16/2023	3	190,923.33	572,769.99	318,205.55	254,564.44
Нийт дүн			17		11,521,473.31	7,349,161.92	4,172,311.39
					(арван нэгэн сая таван зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун далан гурван төгрөг гучин нэгэн мөнгө)	(долоон сая гурван зуун дөчин есөн мянга нэг зуун жаран нэгэн төгрөг ерэн хоёр мөнгө)	(дөрвөн сая нэг зуун далан хоёр мянга гурван зуун арван нэгэн төгрөг гучин есөн мөнгө)